



**АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ТӨРИЙН ӨМЧИГ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1/98

Улаанбаатар хот

**Тээврийн нэгдсэн системд бүртгэх,  
бүртгэлээс хасах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан дүрмийн 4.1.4 дэх заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/24 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын “Тээврийн нэгдсэн системд тээвэрлэгч бүртгэх, бүртгэлээс хасах шалгуур”-ийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Ачаа тээврийн хэлтэс /О.Энхбат/-т, үйлдвэрийн газрын <https://www.transdep.mn/> сайтад байршуулан нийтэд мэдээлэхийг Мэдээлэл технологийн хэлтэс /И.Нэргүй/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Ц.Эрдэнэчулуун/-д тус тус даалгасугай.


ЗАХИРАЛ



Б.ГҮРСОРОНЗОН

000000647

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирлын  
2022 оны .04 дүгээр сарын 04-ний өдрийн  
дугаар тушаалын 4 хавсралт



## ТЭЭВРИЙН НЭГДСЭН СИСТЕМД ТЭЭВЭРЛЭГЧ БҮРТГЭХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ШАЛГУУР

### НЭГ. СИСТЕМД БҮРТГҮҮЛЭХ ТЭЭВЭРЛЭГЧЭЭС ШААРДАХ БИЧИГ, БАРИМТ

Тээврийн нэгдсэн системд бүртгүүлэхийг хүссэн аж ахуйн нэгж байгууллагууд албан хүсэлт гарган дараах материалуудыг бүрдүүлж <https://teeever.transdep.mn/login> цахим хаягт байршуулсан байна. Үүнд:

1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа (e-монголиа портал сайт болон төрийн үйлчилгээний /ТҮЦ/ цахим машинаас авах боломжтой);
2. Аж ахуйн нэгж, байгууллагын танилцуулга (Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрмийн 8.7 дэх заалтыг хангасан байдлыг дэлгэрэнгүй оруулсан байх);
3. Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрмийн 2.16 дахь заалтад заасан тооноос багагүй өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэлтэй байх ба тээврийн хэрэгсэл тус бүрийг Автотээврийн хяналтын Улсын байцаагчийн шалгах хуудсаар шалгуулж, баталгаажуулсан шалгах хуудаснууд;
4. Мэдүүлсэн тээврийн хэрэгслийн тооноос багагүй мэргэшсэн жолооч (С, Е ангилалтай, Улс хоорондын ачаа тээврийн чиглэлээр мэргэшсэн байх)-той байх ба жолооч нарын мэдээлэл бүхий жагсаалт;
5. “Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ MNS 5346:2017” стандартын зэрэглэлд нийцсэн удирдах болон инженер техникийн ажилтан, тээвэр зохицуулагч, ХАБЭА-ын ажилтантай байх ба тэдгээрийн мэдээллийг нэгтгэсэн жагсаалт, тус бүрийн хөдөлмөрийн гэрээний хуулбар, мэргэжлийн дипломын нотариатаар баталгаажуулсан хуулбар;
6. Уурхай эзэмшигч байгууллагатай байгуулсан тээвэрлэлтийн гэрээ;
7. Худалдан авагч талтай байгуулсан гэрээ;
8. Тээврийн хэрэгсэл тус бүрийг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын байршил тогтоох хяналтын системтэй холбож, “Үйлчилгээ үзүүлэх /GPS-ын/ гэрээ” байгуулсан байх;
9. Батлагдсан маршрутын дагуу авто зам эзэмшигчтэй байгуулсан гэрээ /Гашуунсухайт болон Шивээхүрэн боомтоор тээвэрлэлт гүйцэтгэхийг хүсэгчийн хувьд/;
10. Автотээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг хангах зориулалтын засвар үйлчилгээний байгууламж, хадгалах дулаан байр зогсоол, тээвэрлэлт гүйцэтгэх жолоочийг амраах хооллох байр, бусад ажилчдыг байршуулах зориулалт бүхий өөрийн, эсхүл түрээсийн байртай эсэх талаар газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар болон түрээсийн гэрээний хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байх;

### ХОЁР. УЛС ХООРОНД АЧАА ТЭЭВЭРЛЭГЧИЙГ ТЭЭВРИЙН НЭГДСЭН СИСТЕМЭЭС ХАСАХ

Сүүлийн 2 жилийн хугацаанд Тээврийн нэгдсэн системд тээвэрлэлтийн мэдээ оруулаагүй, хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийн бичиг олгогдоогүй тээвэрлэгчийг Тээврийн нэгдсэн системийн бүртгэлээс хасна.